

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар / /

Улаанбаатар
хот

Жагсаалт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Агаарын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжид ариун цэврийн хамгаалалтын бүс тогтоож хүн амын суурьшлын бүсээс зааглах бөгөөд уг бүсийн хэмжээг үйлдвэрлэл, үйлчилгээний салбар, төрөл бүрээр тогтоосон жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, Ерөнхий шаардлага MNS 5105:2001 стандартад дурдагдаагүй аж ахуйн нэгж, байгууллагад эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээг тогтооход хавсралтад заасан ангилал, хамгаалалтын бүсийн хэмжээг дагаж мөрдсүгэй.

3. Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжид ариун цэврийн хамгаалалтын бүс тогтоож хүн амын суурьшлын бүсээс зааглах бөгөөд уг бүсийн хэмжээг үйлдвэрлэл, үйлчилгээний салбар, төрөл бүрээр тогтоосон жагсаалтыг мөрдүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн газар /Д.Баярболд/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар /С.Сүнчин/-т тус тус үүрэг болгосугай.

САЙД

С.ЧИНЗОРИГ

**Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжаас ялгарах
бохирдлоос суурин газрын агаарыг хамгаалах ариун цэврийн
хамгаалалтын бүсийн жагсаалт**

	Үйлдвэрийн тодорхойлолт	Хамгаалалтын бүсийн хэмжээ
1.	Химийн бүтээгдэхүүний үйлдвэр	
1.1	Хоногт 0.5 тонн хүхэрлэгтэй нефтийг гаргах үйлдвэр	1000 м
1.2	Өдөрт 0,5-1 тонн хүхэрт устөрөгчийн ялгаруулалттай, түүнчлэн дэгдэмхий нүүрстөрөгчийн өндөр агууламжтай газрын тос үйлдвэрлэх үйлдвэрлэлийн байгууламжууд	1000 м
1.3	0,5 хувиас бага хүхэрт нефть боловсруулах үйлдвэр	500 м
1.4	Базалт хөвөнгийн үйлдвэр	500 м
1.5	Винил хлорид дээр суурилсан хуванцарын үйлдвэрлэл	500 м
1.6	Давирхай, түүний шаарыг боловсруулах үйлдвэр	500 м
1.7	Дэгдэмтгий органик уусгагчийг хэрэглэж хиймэл арьс хийдэг үйлдвэр	500 м
1.8	Нүүрс ба хүдэр хэрэглэж цагт 25000-50000 м ³ генераторын хий гаргадаг үйлдвэр	500 м
1.9	Органик нийлэг бүтээгдэхүүний үйлдвэр /спирт, этилийн спирт гэх мэт/, цагт 5000 м ³ -ээс их нефтийн хий боловсруулах үйлдвэр	500 м
1.10	Хуванцаржуулагчийн үйлдвэрлэл	500 м
1.11	Хүхэрт устөрөгчийг ашиглан хлорлог бари гаргадаг үйлдвэр	500 м
1.12	Цууны хүчлийн үйлдвэр	500 м
1.13	Шингэрүүлсэн аммиакийн агуулах	500 м
1.14	Шүвтэрийн үйлдвэр	500 м
1.15	Эфирийг ашиглаж хуванцар хийдэг үйлдвэр	500 м
1.16	Эфирын үйлдвэр	500 м
1.17	Давс боловсруулах, нунтаглах үйлдвэрлэл	100 м
1.18	Полиуртан үйлдвэрлэх	100 м
1.19	Савангийн үйлдвэрлэл	100 м
1.20	Хуванцар боловсруулах үйлдвэрлэл /цутгах, шахах, вакуум хэлбэржүүлэх/	100 м
1.21	Бетоны химийн нэмэлт боловсруулах үйлдвэр	100 м

2.	Газрын тосны бүтээгдэхүүн олборлох, агуулах, түгээх	
2.1	Нефтийн байгалийн хий боловсруулах үйлдвэр	500 м
3.	Төмөрлөгийн үйлдвэр	
3.1	1500 м ³ хүртэл багтаамж бүхий зуухтай хүдрийн баяжмалаас шууд төмөр хайлуулах үйлдвэр	1000 м
3.2	Коксийн үйлдвэрлэл /коксийн хий/	1000 м
3.3	Нисэх онгоцны үйлдвэрлэл, засвар үйлчилгээ	1000 м
3.4	Төмөр хийцийн үйлдвэрлэл	1000 м
3.5	Тусгай төмөр хайлуулах үйлдвэрлэл, төмөр хайлш үйлдвэрлэх	1000 м
3.6	Хаягдал боловсруулах цехтэй ил зуух болон хувиргах аргаар ган үйлдвэрлэх /шаар нунтаглах гэх мэт/	1000 м
4.	Хүдэр ба төмрийн хүдэр олборлох үйлдвэр	
4.1	Хүдрийн баяжуулах үйлдвэр	10 км
4.2	Өдөрт 0.5-1 тонн хүхэрт устөрөгчийн ялгаруулалттай, түүнчлэн дэгдэмхий нүүрстөрөгчийн өндөр агууламжтай газрын тос үйлдвэрлэх үйлдвэрлэлийн байгууламжууд	1000 м
4.3	Уулын баяжуулах үйлдвэрүүд	1000 м
4.4	Нунтаг нүүрс ба хүдрээр шахмал түлш хийх үйлдвэр	1000 м
4.5	Ил уурхайн аргаар төмрийн хүдэр, чулуулаг олборлох үйлдвэрлэлийн байгууламж	500 м
4.6	Дэгдэмхий нүүрстөрөгчийн агууламж багатай өдөрт 0.5 тонн хүртэл хүхэрт устөрөгч ялгаруулдаг газрын тос үйлдвэрлэх үйлдвэрийн байгууламжууд	300 м
4.7	Хүдэр, чулуу, хүрэн болон бусад нүүрс олборлох үйлдвэрлэлийн байгууламжууд	300 м
4.8	Чийгтэй аргаар баяжуулалт хийх үйлдвэр	300 м
5.	Барилгын материалын үйлдвэр	
5.1	Гипс /алебастр/ үйлдвэрлэл	500 м
5.2	Цемент /портланд-шлак, портланд-позолон-цемент гэх мэт/, орон нутагт цемент /шавар цемент, ром цемент, гипс-шлак гэх мэт/ үйлдвэрлэл	500 м
5.3	Байгалийн чулуу боловсруулах үйлдвэрлэл	300 м
5.4	Байшин барих үйлдвэр	300 м
5.5	Барилгын полимер материалын үйлдвэрлэл	300 м
5.6	Бетон болон бетон эдлэлийн үйлдвэрлэл	300 м
5.7	Буталсан чулуу, хайрга, элс үйлдвэрлэх, кварцын элсийг баяжуулах	300 м
5.8	Дээврийн материал үйлдвэрлэх	300 м

5.9	Тоосго /улаан, цагаан/, барилгын керамик, галд тэсвэртэй бүтээгдэхүүний үйлдвэрлэл	300 м
5.10	Төмөр бетон эдлэлийн үйлдвэрлэл /бетон бүтээгдэхүүн, төмөр бетон эдлэл/	300 м
5.11	Урлагийн цутгамал, болор үйлдвэрлэл	300 м
5.12	Хиймэл дүүргэгч /өргөтгөсөн шавар гэх мэт/ үйлдвэрлэх	300 м
5.13	Хиймэл чулуун үйлдвэрлэл	300 м
5.14	Чулуу цутгах үйлдвэрлэл	300 м
5.15	Шаазан эдлэлийн үйлдвэрлэл	300 м
5.16	Арматур цутгах үйлдвэр	300 м
5.17	Базальт хөвөн (чулуун)-гийн үйлдвэр	300 м
5.18	Бетон зуурмаг үйлдвэрлэх, суурилуулалт	100 м
5.19	Хайрга, элс, шавар олборлох карьер, аж ахуйн нэгж	100 м
5.20	Шаварлаг бүтээгдэхүүний үйлдвэрлэл	100 м
5.21	Блокийн үйлдвэр	100 м
5.22	Шил хатаах үйлдвэр	100 м
6.	Мод боловсруулах үйлдвэр	
6.1	Модыг химийн аргаар боловсруулах үйлдвэр	1000 м
6.2	Тавилгыг лак будгаар будаж угсрах үйлдвэрлэл	100 м
6.3	Хөрөө тээрэм, фанер, модон эдлэлийн эд анги үйлдвэрлэл	100 м
6.4	Шилмүүст-витамин гурил, хлорфилл-каротин зуурмаг, шилмүүс модны ханд үйлдвэрлэл	100 м
6.5	Давсны уусмал ба усан уусмал ашиглан супер бүрээстэй мод бэлтгэх /хүнцлийн давсгүй/	50 м
7.	Нийгэм, ахуйн үйлчилгээний байгууламжууд	
7.1	Хүний цогцос чандарлах газар	1000 м
8.	Цахилгаан болон дулааны эрчим хүчний үйлдвэр	
8.1	Дулааны станц	1000 м
8.2	Нүүрс, мазутыг түлш болгон ашигладаг 600 МВт ба түүнээс дээш тэнцүү цахилгаан эрчим хүч бүхий дулааны цахилгаан станц	1000 м
8.3	Хийн болон хийн түлшний түлшээр ажилладаг 600 МВт ба түүнээс дээш тэнцүү цахилгаан эрчим хүч бүхий дулааны цахилгаан станц	500 м
8.4	Нүүрс, нефтийн түлшээр ажилладаг 200 Гкал ба түүнээс дээш дулааны хүчин чадалтай дулааны цахилгаан станц, бүсийн уурын зуух	500 м

8.5	Хийн болон хийн түлшний түлшээр ажилладаг 200 Гкал ба түүнээс дээш дулааны хүчин чадалтай дулааны цахилгаан станц, уурын зуух	300 м
8.6	Дулааны цахилгаан станцын үнсний овоолго	300 м
9.	Агро аж үйлдвэрийн цогцолбор, жижиг бизнесийн объект үйлдвэрлэл	
9.1	Бууц хогийн задгай агуулах	1000 м
9.2	Гахайн үржүүлгийн цогцолбор	1000 м
9.3	4-12 мянган толгой гахайн ферм	500 м
9.4	Жилд 400 мянгаас олон өндөглөгч, 3 саяаас олон тахиа тэжээдэг шувууны ферм	1000 м
9.5	Шувууны ферм 100 - 400 мянга хүртэл өндөглөгч, 1 сая хүртэл өндөглөгч тахиа	500 м
9.6	2 т/цагаас дээш хүчин чадалтай тээрэм, үр тарианы тээрэм, тэжээлийн үйлдвэр	300 м
9.7	1200-2000 үхрийн ферм, 6000 хүртэлх тооны төл малын газар	500 м
9.8	500 тонноос дээш пестицид хадгалах агуулах	500 м
9.9	Бууц, хог хаягдлын битүү хадгалах агуулах	500 м
9.10	Үслэг фермүүд /булга, үнэг гэх мэт/	500 м
9.11	Ачааны машин, хөдөө аж ахуйн машин механизмын засвар, хадгалах зориулалттай 1 граж, парк	300 м
9.12	Ашигт малтмалын бордоо, пестицидийг 5 тонн хүртэл хадгалах агуулах	100 м
9.13	Фермүүд /гахай, үхрийн хашаа, үржүүлгийн газар, жүчээ, 100 хүртэл малтай малын ферм/	100 м
9.14	Хуурай эрдэс бордоо, ургамал хамгаалах химийн бодисын агуулах	100 м
9.15	Хүлэмж, хүлэмжийн байгууллага	100 м
9.16	Жимс, хүнсний ногоо, төмс, ур тариа хадгалах	50 м
9.17	Материалын агуулах	50 м
9.18	Фермүүд /гахай, үхрийн хашаа, үржүүлгийн газар, жүчээ, 50 хүртэл малтай малын ферм/	50 м
10.	Хөнгөн үйлдвэр	
10.1	Ээрэх, нэхэх үйлдвэрлэл	300 м
10.2	Гутал үйлдвэрлэл	100 м
10.3	Оёдлын үйлдвэрлэл	100 м
10.4	Оймсны үйлдвэр	100 м
10.5	Спортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл	100 м
10.6	Сүлжмэлийн үйлдвэрлэл	50 м

10.7	Усанд уусдаг цавуу ашиглан эцсийн материалаар гутал үйлдвэрлэх бага оврын үйлдвэрлэл	50 м
10.8	Хивсний үйлдвэрлэл	50 м
11.	Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэр	
11.1	Арьс ширний үлдэгдэл, талбайн болон овоолгын яс болон бусад амьтны хог хаягдлаас цавуу гаргах үйлдвэр	1000 м
11.2	Мал төхөөрөх болон мах боловсруулах үйлдвэр нь дэргэдээ хамгаалагдсан аж ахуйтай нөхцөлд	1000 м
11.3	Талбайн ялзарсан яс, мездра, арьсны үлдэгдэл болон бусад амьтны хог хаягдал, хог хаягдлаас техникийн желатин үйлдвэрлэх, хадгалах	1000 м
11.4	Үхсэн амьтан, загас, тэдгээрийн эд анги бусад амьтны хог хаягдал, хог хаягдлыг боловсруулах үйлдвэрлэлийн байгууламж /өөх тос, малын тэжээл, бордоо гэх мэт/	1000 м
11.5	Яс шатаах нунтаглах үйлдвэр	1000 м
11.6	Малын яс боловсруулах үйлдвэр	500 м
11.7	Гахайн өөхний үйлдвэрлэл /техникийн өөхний үйлдвэрлэл/	500 м
11.8	Мал тээвэрлэсний дараа вагон цэвэрлэх, угаах станц, цэг /буулгах станц, цэг/	500 м
11.9	Ноос, ноолуур угаах, боловсруулах үйлдвэр	300 м
11.10	Арьс ширний үйлдвэрлэл	300 м
11.11	Малын гаралтай түүхий эд боловсруулах, будах /нэхий дээл, нэхий болон арьс шир боловсруулах, үслаг эдлэл/, илгэн эдлэлийн үйлдвэрлэл	300 м
11.12	Малын түүхий арьс боловсруулах үйлдвэрлэл /хаягдал ашиглах/	300 м
11.13	Нойтон давсалсан болон түүхий арьсыг түр хадгалах агуулах	100 м
11.14	Эсгий, эсгий үйлдвэрлэл	100 м
12.	Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэр	
12.1	Мал төхөөрөх үйлдвэр	500 м
12.2	Өлөн гэдэс боловсруулах үйлдвэр	500 м
12.3	Тахианы аж ахуй	300 м
12.4	Загасны үйлдвэр	300 м
12.5	Тэжээлийн антибиотекийн үйлдвэр	300 м
12.6	Өндөр хүчин чадалтай (2000м.кв-аас дээш талбайтай) төрөлжсөн хүнсний агуулах	300 м
12.7	Тамхины үйлдвэрлэл	100 м
12.8	Гурилын үйлдвэр	100 м
12.9	Мах боловсруулах үйлдвэр	100 м

12.10	Малын дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр	100 м
12.11	Спирт, архи, дарсны үйлдвэр	100 м
12.12	Бяслагны үйлдвэрлэл	100 м
12.13	Эрдэнэ шиш, цардуулын үйлдвэр	100 м
12.14	Ургамлын болон амьтаны гаралтай тос боловсруулах үйлдвэрлэл	100 м
12.15	Жимс, хүнсний ногоог боловсруулах/хатаах, давслах, даршлах/ үйлдвэр	100 м
12.16	Өдөрт 1 тонноос дээш хүчин чадалтай чихрийн үйлдвэрлэл	100 м
12.17	Өдөрт 3.1 тонноос дээш хүчин чадалтай талх, талх бүтээгдэхүүн, нарийн боовны үйлдвэрүүд	100 м
12.18	Дунд хүчин чадалтай (500-2000м.кв талбайтай) төрөлжсөн агуулах	100 м
12.19	Хагас боловсруулсан махан бүтээгдэхүүний үйлдвэр	50 м
12.20	Бага хүчин чадалтай(500 м.кв хүртэл талбайтай) үйлдвэрийн болон худалдааны агуулах	50 м
12.21	Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр	50 м
12.22	Гоймон, пүнтүүз, хэрчсэн гурилын үйлдвэр	50 м
12.23	Шар айраг, шимийн архины үйлдвэрлэл	50 м
12.24	Өдөрт 1 тонноос бага хүчин чадалтай чихрийн үйлдвэрлэл	50 м
12.25	Өдөрт 3 тонноос бага хүчин чадалтай талх, талх бүтээгдэхүүн, нарийн боовны үйлдвэрүүд	50 м
12.26	Майонез үйлдвэрлэл	50 м
12.27	Цайны үйлдвэр	50 м
12.28	Савлах үйлдвэр	50 м
12.29	Хоолны цууны үйлдвэр	50м
12.30	Савласан ус, төрөл бүрийн ундаа, жимс, жимсгэнэ, ногооны шүүсний үйлдвэрлэл	50м
12.31	Биологийн идэвхит бүтээгдэхүүний үйлдвэрлэл	50м
13.	Микробиологийн үйлдвэрлэл	
13.1	Альбумин үйлдвэрлэх	500 м
13.2	Антибиотикийн үйлдвэрлэл	500 м
13.3	Декстрин, глюкоз, моллас үйлдвэрлэх	500 м
13.4	Вакцин, ийлдэс үйлдвэрлэх	300 м
14.	Бусад	
14.1	Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр	1000 м
14.2	Хаягдал дугуй боловсруулах үйлдвэр	1000 м
14.3	Аккумуляторын үйлдвэр	1000 м

14.4	Тэжээлийн үйлдвэр /хоолны хаягдлаас малын тэжээл үйлдвэрлэх/	300 м
14.5	Уламжлалт эмийн үйлдвэр, хуш модны самар боловсруулах үйлдвэр	100 м

ooOoo